# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

**№ 32 (557)**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай*
- *Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

**Улаанбаатар хот**

**2008 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2008 оны наймдугаар сарын 28 | №32 (557)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 544. | ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 231 | 933 |
| 545. | Ноён Нурсултан Абишевич Назарбаевыг сувдан шигтгээт "Эрдэнийн очир" одонгоор шагнах тухай | Дугаар 232 | 934 |
| 546. | Ясуёоши Ичихаши-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай | Дугаар 233 | 934 |
| 547. | Зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай | Дугаар 234 | 934 |
| 548. | Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай | Дугаар 235 | 941 |
| 549. | Владимир Егорович Проничевыг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 241 | 941 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 550. | Цахилгаан шат шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 248 | 941 |
| 551. | Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай | Дугаар 252 | 942 |
| 552. | Зээл олгох тухай | Дугаар 254 | 942 |
| 553. | Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шатыг батлах тухай | Дугаар 256 | 942 |
| 554. | Журам батлах тухай | Дугаар 260 | 945 |
| 555. | Хүүхдийн төлөө сангийн дүрэм, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай | Дугаар 261 | 947 |
| 556. | Цөмийн энергийн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 263 | 949 |
| 557. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 264 | 950 |
| 558. | Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай | Дугаар 266 | 950 |
| 559. | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 282 | 951 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| 2008 оны 08 дугаар сарын 01-ний өдөр | Дугаар 231 | Улаанбаатар хот |
|---|---|---|

### ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн дараахь хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Кушнир Леонид Григорьевич - ОХУ-ын "Росстройизыскания" нийгэмлэгийн ерөнхий захирал, "Монголын анд нөхөд" нийгэмлэгийн тэргүүн дэд ерөнхийлөгч

**"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:**

1. Цендина Анна Дамдиновна - Москва хотын Хүмүүнлэгийн их сургуулийн доктор, профессор, "Монголын анд нөхөд" нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн

2. Бабушкин Владимир Алексеевич - "Монголын анд нөхөд" нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч, хариуцлагатай нарийн бичгийн дарга

3. Иванов Пётр Игоревич - "Монголын анд нөхөд" нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч

4. Максимов Эдуард Викторович - "Монголын анд нөхөд" нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн

5. Буянов Владимир Петрович - Москва хотын Эдийн засаг ба хуулийн академийн ректор, "Монголын анд нөхөд" нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 06-ны өдөр** **Дугаар 232** **Улаанбаатар хот**

### Ноён Нурсултан Абишевич Назарбаевыг сувдан шигтгээт "Эрдэнийн очир" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөн хүрээтэй түншлэлийн түвшинд гарган хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч, эрхэмсэг ноён Нурсултан Абишевич Назарбаевыг сувдан шигтгээт "Эрдэнийн очир" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 07-ны өдөр** **Дугаар 233** **Улаанбаатар хот**

### Ясуёоши Ичихаши-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ясуёоши Ичихаши-г "Алтан гадас" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 07-ны өдөр** **Дугаар 234** **Улаанбаатар хот**

### Зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай

"Иракийн эрх чөлөө", Сьерра Леон Улс дахь НҮБ-ын Энхийг сахиулах хүмүүнлэгийн олон улсын цэргийн ажиллагаанд оролцож албан үүргээ нэр төртэй биелүүлсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн дор дурдсан офицер, ахлагч нарыг медалиар шагнасугай.

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Дашживаагийн Ариунболд - ЗХЖШ-ын Энхийг дэмжих, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн, хошууч

2. Рэнцэндоржийн Батдэлгэр - Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн мэс засал, гэмтлийн кабинетийн эрхлэгч-мэс заслын их эмч, дэд хурандаа

3. Ишжамцын Баярхүү - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн мэс заслын их эмч, ахмад

4. Цэрэнчимэдийн Буянтогтох - БХИС-ийн Цэргийн команд, инженерийн сургуулийн багш, хошууч

5. Баатарын Гэрэлчулуун - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн эмнэлгийн дарга, хошууч

6. Гришийн Нэмэхбаяр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн артиллерийн батарейны захирагч, ахмад

7. Лхамжийн Онцгойбаяр - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

8. Дагвадоржийн Энхцог - ЗХЖШ-ын Тусгай үүргийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, хошууч

9. Раднаабазарын Эрдэнэбилэг - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

**"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИАР:**

1. Адъяагийн Алтаншагай - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 104 дүгээр тусгай салбарын тасгийн захирагч-ахлах оператор, дэд ахлагч

2. Энхжаргалын Амарбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ротын ажиллагааны офицер, дэслэгч

3. Төмөрбаатарын Амарсанаа - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн буудлагын талбайн дарга, ахлах ахлагч

4. Цэгмидийн Амарсанаа - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хөгжимчин, ахлагч

5. Болдбаатарын Амгаланбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик, дэд ахлагч

6. Тогтохын Амартүвшин - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн тагнуулын дарга, ахлах дэслэгч

7. Даваажавын Анарчулуун - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн дизель агрегатын засварын инженер, ахлах дэслэгч

8. Бадарчийн Атарбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагчийн орлогч, дэд ахлагч

9. Батменхийн Баатарсүрэн - Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн мэс заслын их эмч, дэслэгч

10. Дандарын Баатарсүх - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн механик жолооч, ахлах ахлагч

11. Дамдинсүрэнгийн Баатархүү - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

12. Хүрэлбаатарын Баатархүү - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч

13. Батнасангийн Бадамсэрээжид - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

14. Ширчинжавын Бадамцэрэн - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн соёлын төвийн дарга, ахлах дэслэгч

15. Лхагваагийн Бат - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн хуягт танкийн засварчин, ахлагч

16. Ганболдын Батбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн засварчин, дэд ахлагч

17. Онгойн Батбаяр - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 253 дугаар тусгай салбарын станцын дарга, ахлах ахлагч

18. Өвөөгийн Батбаяр - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн сахилгын хорих байрын хүмүүжүүлэгч, ахлагч

19. Үрлээгийн Батбаяр - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 328 дугаар тусгай салбарын салааны захирагч, дэслэгч

20. Хорлоогийн Батбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

21. Доржпагмын Батболд - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн танкийн механик жолооч, дэд ахлагч

22. Шижирвандангийн Батдорж - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагчийн орлогч, дэд ахлагч

23. Аюушжавын Батмөнх - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч

24. Баттулгын Батмөнх - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

25. Доржбатын Батмөнх - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 143 дугаар тусгай салбарын тусгай холбооны мэргэжилтэн, ахлагч

26. Цагаандаргын Батмөнх - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 323 дугаар тусгай салбарын харвах суурийн ахлах номер, ахлагч

27. Пүрэвийн Батнайрамдал - Соёмбо сонины орлогч эрхлэгч, ахлах сурвалжлагч, дэд хурандаа

28. Өлзийжаргалын Батнаран - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч

29. Бираадамбын Батнасан - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

30. Сэр-Одын Батнямм - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр тусгай салбарын планшетчин, дэд ахлагч

31. Чинбатын Бат-Оргил - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн гэрээт цэргийн албан хаагч, байлдагч

32. Буянтын Бат-Өлзий - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч

33. Хүрэлхуягийн Бат-Өлзий - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн цахилгаанчин-жолооч, дэд ахлагч

34. Пүрэвсүрэнгийн Батсүрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

35. Балдандоржийн Батсүх - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн харуулчин, дэд ахлагч

36. Намжилдоржийн Баттөмөр - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хорооны ахлагч, сургагч ахлагч

37. Дэнзэнгийн Баттулга - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сумлагч, дэд ахлагч

38. Бямбацогтын Бат-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч

39. Эрдэнэчимэгийн Бат-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч

40. Даваасүрэнгийн Баянмөнх - БХИС-ийн Цэргийн команд, инженерийн сургуулийн дадлагын багш жолооч, ахлагч

41. Санжаахүүгийн Баярмэнд - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

42. Ганболдын Баярсайхан - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

43. Содномын Баярцогт - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 086 дугаар тусгай салбарын оперативын жижүүр, ахлах ахлагч

44. Олонбаярын Баясгалан - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сургагч багш, ахлагч

45. Далхаагийн Биндэръяа-Од - Хилийн 0151 дүгээр ангийн мэргэн буудагч, ахлагч

46. Мангаагийн Болдбаатар - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, хошууч

47. Чогдонгийн Болдбаатар - БХИС-ийн Цэргийн команд, инженерийн сургуулийн багш, дэд хурандаа

48. Урантогосын Болдбаяр - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 253 дугаар тусгай салбарын оператор, дэд ахлагч

49. Чойбаатарын Болдхүү - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч

50. Нямдоржийн Болд-Эрдэнэ - Хилийн 0306 дугаар ангийн заставын орлогч, дэслэгч

51. Бат-Өлзийн Бүрэнзэвсэг - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хадгалах тасгийн дарга, ахлах дэслэгч

52. Балжиннямын Бүрэнтөгс - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн санхүүгийн дарга, ахлах нягтлан бодогч, ахмад

53. Доржхоролын Бямбасүрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

54. Цэдэнжавын Бямбацогт - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн авто тээврийн салааны захирагч, дэслэгч

55. Жадлаажийн Ганбаатар - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 281 дүгээр тусгай салбарын оператор, ахлах ахлагч

56. Мягмарын Ганбат - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн сургагч багш, дэслэгч

57. Сарангэрэлийн Ганбат - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн сэтгэл зүйч, дэслэгч

58. Хурцбилэгийн Ганбаяр - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн гагнуурчин, дэд ахлагч

59. Самдангийн Ганболд - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн жолооч, ахлагч

60. Ганболдын Ганзориг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

61. Дамбанямын Ганзориг - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн ахлах оператор, дэд ахлагч

62. Энхбаярын Ганзориг - Хилийн 101 дүгээр ангийн сургалтын офицер, дэслэгч

63. Баажаагийн Гансүх - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн ротын захирагч, ахлах дэслэгч

64. Гомбосүрэнгийн Гансүх - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

65. Пунцагдашийн Гантөгс - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч

66. Цэндсүрэнгийн Гантөгс - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн мотобуудлагын батальоны соёл хүмүүжлийн дарга, ахлах дэслэгч

67. Цэдэндамбын Гантулга - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 090 дүгээр тусгай салбарын аж ахуйн дарга, дэд ахлагч

68. Сэр-Одын Ганхуяг - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн батальоны ахлагч, тэргүүн ахлагч

69. Зоригтын Гүндэгсамбуу - Хилийн 0101 дүгээр ангийн биеийн тамирын дарга, дэслэгч

70. Гонгорын Гүррагчаа - Хил хамгаалах ерөнхий газрын хувцасны хангалтын офицер, технологич, хангалтын мэргэжилтэн, дэслэгч

71. Сосорбарамын Дайрийбаатар - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн зангилгааны даргын техникийн орлогч, дэслэгч

72. Лхагвасүрэнгийн Даваа - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн хараачин, дэд ахлагч

73. Хишигсүрэнгийн Даваацогт - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 323 дугаар тусгай салбарын харвах суурийн ахлах номер, ахлагч

74. Эрдэнийн Даваацэрэн - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн жолооч-цахилгаанчин, ахлах ахлагч

75. Даваадоржийн Даваахүү - Хилийн 0131 дүгээр ангийн хилийн албаны офицер, ахлах дэслэгч

76. Цэдэнбалын Даваа-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн тасгийн захирагч, тагнуулчин, дэд ахлагч

77. Сэржгочоогийн Далайбаяр - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн оператор, ахлагч

78. Лхагвасүрэнгийн Дамдинсүрэн - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр тусгай салбарын оператор-жолооч, ахлагч

79. Бадамцэдэнгийн Данзандорж - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 090 дүгээр тусгай салбарын аж ахуйн дарга, дэд ахлагч

80. Сэргэлэнгийн Дорждэрэм - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик, дэд ахлагч

81. Шижирбаатарын Дэлгэрдалай - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн харуулын дарга, ахлагч

82. Ганбатын Дэлгэрсайхан - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн хөгжимчин, ахлагч

83. Учралын Дэлгэрсайхан - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн механик жолооч, ахлах ахлагч

84. Бандийн Заяабат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

85. Магсарын Золзаяа - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн зэвсгийн нярав засварчин, ахлагч

86. Бямбасүхийн Жаргалбаатар - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн оператор бичигч, дэд ахлагч

87. Жигжидсүрэнгийн Жамъяндорж - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн оператор, дэд ахлагч

88. Батбаярын Идэрбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

89. Долгорын Мартбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

90. Аюурзаны Мөнгөнбаяр - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн зохицуулагч ахлагч, дэд ахлагч

91. Дугаржавын Мөнхбадрал - Хилийн 0198 дугаар ангийн биеийн тамирын дарга, дэслэгч

92. Дондогдоржийн Мөнхбаатар - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн ар талын даргын орлогч, авто техникийн дарга, ахлах дэслэгч

93. Бадамын Мөнхбат - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбарын оператор-жолооч, ахлагч

94. Гантөмөрийн Мөнхбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн бууны захирагч, ахлагч

95. Алтангэрэлийн Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч

96. Мягмарын Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн үлээвэр найрал хөгжмийн удирдаач, дэслэгч

97. Төмөртогоогийн Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн химийн дарга, хошууч

98. Энхболдын Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч

99. Эрдэнээгийн Мөнхбаясгалан - Хилийн 0131 дүгээр ангийн заставын орлогч, дэслэгч

100. Ширчинбазарын Мөнхдалай - БХИС-ийн Ахлагчийн сургуулийн дамжааны багш, сургагч ахлагч

101. Баттулгын Мөнхжаргал - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч

102. Энхбаатарын Мөнхсоёл - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн гэрээт цэргийн албан хаагч, байлдагч

103. Цагаанхүүгийн Мөнхтүвшин - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн ротын захирагч, ахлах дэслэгч

104. Даваацэрэнгийн Мөнхтөр - Тагнуулын ерөнхий газрын ажилтан, ахлах ахлагч

105. Дашдондовын Мөнх-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн ротын жагсаалын дарга, ахлагч

106. Бат-Очирын Мягмаржав - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн хуягт танкийн дарга, хошууч

107. Болдын Мягмарсүрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн зэвсгийн нярав, дэд ахлагч

108. Сугарын Мягмарсүрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, ахлагч

109. Очирбатын Мягмарцэрэн - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн автын засварчин, дэд ахлагч

110. Мухраагийн Нарангэрэл - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн артиллерийн зэвсэглэлийн засварчин, дэд ахлагч

111. Базаррагчаагийн Нямдаваа - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн харуулчин, дэд ахлагч

112. Зовадханы Нурбек - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 116 дугаар тусгай салбарын ахлах оператор, дэд ахлагч

113. Сэрвэдийн Нэргүй - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн станцын дарга-жолооч, ахлагч

114. Баатархүүгийн Нямбаяр - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жолооч, дэд ахлагч

115. Самбуугийн Одбаяр - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, дэд хурандаа

116. Мажигийн Одгэрэл - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн харуулчин, дэд ахлагч

117. Энхтүшигийн Орхонтуул - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн кабельчин, ахлагч

118. Бямбажавын Отгонбаатар - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн инженерийн механик жолооч, дэд ахлагч

119. Сүхбаатарын Отгонбат - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 252 дугаар салбарын тасгийн захирагч, ахлагч

120. Чулуунбатын Отгонбат - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн химийн засварын цехийн тасгийн захирагч, дэд ахлагч

121. Долгорын Отгонбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн хадгалах тасгийн нярав, дэд ахлагч

122. Оюун-Эрдэнийн Отгонбаяр - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн гэрээт цэргийн албан хаагч, байлдагч

123. Чойжилсүрэнгийн Отгонбаяр - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн химичин жолооч, дэд ахлагч

124. Цэдэн-Ишийн Отгонтэгс - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн мотобуудлагын батальоны соёл хүмүүжлийн дарга, ахлах дэслэгч

125. Цэрэнпүрэвийн Отгонцэрэн - ЗХЖШ-ын Ар талын газрын Авто хуягт техникийн хэлтсийн мэргэжилтэн, хошууч

126. Сандрын Очирпүрэв - Хилийн 0277 дугаар ангийн харуулын дарга, ахлагч

127. Доржсүрэнгийн Өлзийбат - Зэвсэгт хүчний 314 дүгээр ангийн галын ээлжийн дарга, ахлагч

128. Түмэнцэрэгийн Өрнөлтбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн моторчин, дэд ахлагч

129. Төмөрбаатарын Пүрэвжав - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн нярав, дэд ахлагч

130. Цэдэндамбын Пүрэв-Очир - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сапёрчин – тэсэлгээчин, дэд ахлагч

131. Төрбаяжихын Пүрэвсүрэн - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн танкийн механик жолооч, ахлах ахлагч

132. Эрдэнэбаатарын Пүрэвцэрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн нярав, дэд ахлагч

133. Дашдаваагийн Ринчиндорж - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн кабель шугамын төвийн дарга, ахлах дэслэгч

134. Насанхүүгийн Сайнбилэг - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 148 дугаар тусгай салбарын тусгай холбооны мэргэжилтэн, ахлагч

135. Мөнхдэлгэрийн Сайнхүү - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 278 дугаар тусгай салбарын нууцын эрхлэгч, дэд ахлагч

136. Мөнхжаргалын Сансар - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн аккумуляторчин, ахлагч

137. Цэрэндашийн Содбаяр - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн байр зүйн зургийн хангалтын офицер, хошууч

138. Батболдын Соронзонбат - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 329 дүгээр тусгай салбарын оперативын жижүүр, дэд ахлагч

139. Чимэдсүрэнгийн Сэрээнэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сансрын холбооны оператор, дэд ахлагч

140. Бат-Эрдэнийн Тайван - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн гэрээт цэргийн албан хаагч, түрүүч

141. Буянтогтохын Тогтохбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик-жолооч, дэд ахлагч

142. Баяраагийн Тэгсбилэг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мини тэсэлгээний техникч, дэд ахлагч

143. Чойжамцын Төмөр - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн жолооч, дэд ахлагч

144. Ганболдын Төрбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн пулемётчин, дэд ахлагч

145. Жамбадуламын Төрмөнх - Зэвсэгт хүчний 314 дүгээр ангийн харуулчин, ахлагч

146. Наваантаягийн Түвшинбаяр - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 278 дугаар тусгай салбарын харуулчин, дэд ахлагч

147. Сосорын Түвшинтөгс - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн санхүүгийн дарга, ахлах дэслэгч

148. Бударгчаагийн Түвшинтөр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик-оператор, дэд ахлагч

149. Очирбатын Түвшинтөр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн химичин-тагнуулчин, дэд ахлагч

150. Чулуунбатын Түмэнбаяр - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн гэрээт цэргийн албан хаагч, байлдагч

151. Өсөхбаярын Тэмүүлэнтэгс - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн машины дарга, дэд ахлагч

152. Баатарцогтын Угтахбаяр - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн жагсаалын дарга, ахлагч

153. Дотиновын Угтахбаяр - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн оператор, ахлагч

154. Билгээгийн Уламжаргал - Хилийн 0253 дугаар ангийн сургалт, соёл хүмүүжлийн дарга, ахмад

155. Баяраагийн Ууганбаяр - БХИС-ийн Цэргийн команд, инженерийн сургуулийн суурин станцын дарга, дэд ахлагч

156. Цэрэндоржийн Ууганбаяр - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 116 дугаар тусгай салбарын ахлах оператор, дэд ахлагч

157. Батболдын Хишигбаяр - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн холбооны дарга, хошууч

158. Рэгзээгийн Хосбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сапёрчин-тэсэлгээчин, дэд ахлагч

159. Бэгзийн Хүрэлчулуун - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн нярав засварчин, ахлах ахлагч

160. Жаргалсайханы Хуягбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн нярав, дэд ахлагч

161. Шаравдоржийн Цогбаяр - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн тасгийн захирагч, ахлах радиотелеграфчин, сургагч ахлагч

162. Янжмаагийн Цогнэмэх - БХИС-ийн станцын дарга, ахлагч

163. Оюунцэцэгийн Цогтсайхан - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

164. Ядамсүрэнгийн Цогтсайхан - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн наводчик-оператор, дэд ахлагч

165. Цэгмидийн Цэдэндамба - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 278 дугаар тусгай салбарын оператор, дэд ахлагч

166. Пүрэв-Ойдовын Цэнд-Аюуш - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн нярав засварчин, дэд ахлагч

167. Цэрэндолгорын Цэндбаатар - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн гэрээт цэргийн албан хаагч, байлдагч

168. Бямбачулууны Цэрэнбат - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хөгжимчин, ахлагч

169. Дамдиндоржийн Чимэдцэрэн - Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн гал командын ээлжийн дарга, ахлагч

170. Бямбаагийн Чинзориг - ЗХЖШ-ын Цэргийн тагнуулын газрын мэргэжилтэн, дэд хурандаа

171. Лувсанцэрэнгийн Чинзориг - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн сэтгэл зүйч, ахлах дэслэгч

172. Нямхүүгийн Чинзориг - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн эргүүл, ахлагч

173. Амарсанаагийн Чулуунбаатар - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жолооч, дэд ахлагч

174. Нямсүрэнгийн Шинэбаяр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн зэвсэг галт хэрэглэл хадгалах тасгийн инженер, дэслэгч

175. Баттулгын Ширнэн - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн авто техник хадгалах тасгийн инженер, дэслэгч

176. Отгон-Уулын Энх-Амар - Зэвсэгт хүчний 084 дугээр ангийн тагнуулын офицер, ахмад

177. Сугархүүгийн Энхбат - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн жолооч, ахлагч

178. Лхагваагийн Энхбаяр - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн эмнэлгийн дарга, дэслэгч

179. Хаданбаатарын Энхбаяр - Зэвсэгт хүчний 014 дугээр ангийн оператор жолооч, ахлагч

180. Нямбуугийн Энхбаясгалан - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ус хангалтын сапёрчин, дэд ахлагч

181. Дамдингийн Энхтулга - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн харуулчин, ахлагч

182. Дашнямын Эрдэнэбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

183. Шагдаржавын Эрдэнэбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ротын захирагч, хошууч

184. Амарсанаагийн Эрдэнэбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч

185. Самдангийн Эрдэнэбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатмётчин, дэд ахлагч

186. Гүрбатын Эрдэнэбилэг - Зэвсэгт хүчний 124 дугээр ангийн техникийн засварын дарга, жолооч, ахлах ахлагч

187. Сонины Эрдэнэцогт - Зэвсэгт хүчний 311 дугээр ангийн биеийн тамир, спортын дарга, хошууч

188. Цэдэндамбын Юндэн - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн ээлжийн техникч, ахлагч

189. Чоёнгийн Юучбиш - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн нярав засварчин, ахлагч

190. Дарьсүрэнгийн Анхбаатар - Дотоодын цэргийн 809 дугээр тусгай салбарын довтлогч, ахлагч

191. Гонгоржавын Баасан-Очир - Тагнуулын ерөнхий газрын ажилтан, дэслэгч

192. Батжаргалын Балжинням - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн наводчик -оператор, дэд ахлагч

193. Баасанжавын Батаа - Зэвсэгт хүчний 124 дугээр ангийн авто техникийн дарга, хошууч

194. Бадамсүрэнгийн Батбаяр - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн станцын дарга жолооч, ахлах ахлагч

195. Батмөнхийн Батбаяр - Хилийн 0168 дугаар ангийн заставын дарга, ахлах дэслэгч

196. Уртнасангийн Батцэнд - Зэвсэгт хүчний 089 дугээр ангийн жолооч, ахлагч

197. Чантуугийн Батчулуун - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн химийн дарга, ахмад

198. Нацагдоржийн Батгомбо - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн мэдээгүйжүүлэгч их эмч, дэслэгч

199. Бартагийн Бат-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн станцын дарга жолооч, ахлах ахлагч

200. Алтанцацралын Бат-Ялалт - Дотоодын цэргийн 809 дугээр тусгай салбарын довтлогч, ахлагч

201. Өлзийхутагийн Баярбадрах - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн бүлгийн дарга, дэслэгч

202. Дамцагдоржийн Баяргэрэл - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн инженер техникийн ротын захирагч, ахлах дэслэгч

203. Бат-Өлзийн Бэххуяг - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

204. Сураагийн Ганбаатар - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жагсаал ангийн дарга, ахлах ахлагч

205. Шаравсамбуугийн Ганбат - ЗХЖШ-ын Цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, хурандаа

206. Даваанямын Ганбилэг - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн зэвсэг засвар үйлчилгээний ротын захирагч, ахлах дэслэгч

207. Энхжаргалын Ганзориг - БХИС-ийн Цэргийн команд, инженерийн сургуулийн дамжааны багш, дэслэгч

208. Мягмарын Ганхүрэл - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн суурийн дарга, ахлах ахлагч

209. Мөнхбаатарын Даваажав - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, дэд ахлагч

210. Жамъянсүрэнгийн Даваарагчаа - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

211. Авидын Дондов - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн үлээвэр найрал хөгжмийн удирдаач, ахлах дэслэгч

212. Осорын Жамбажамц - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн авто техникийн дарга, хошууч

213. Оюунчулууны Ням-Осор - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ротын жагсаалын дарга, ахлагч

214. Бадмаараагийн Оюунболд - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн тасгийн захирагч-тагнуулчин, ахлагч

215. Дашдаваагийн Өлзийбат - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

216. Мягмарын Өрнөх - Дотоодын цэргийн 809 дүгээр тусгай салбарын довтлогч, ахлагч

217. Энхбатын Сайнбаяр - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн тусгай холбооны мэргэжилтэн жолооч, ахлагч

218. Сандагсүрэнгийн Самдангэлэг - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сургагч багш, ахлах дэслэгч

219. Хүрэлчулууны Санчирдорж - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хуягт танкийн техник хадгалах тасгийн дарга, ахлах дэслэгч

220. Батхишигийн Сүхбаатар - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн ахлах гүүрчин-жолооч, ахлагч

221. Энхбаатарын Сүхбаатар - Хилийн 0101 дүгээр ангийн хилчин-шалгагч, жагсаалын дарга, ахлагч

222. Лхагвадоржийн Тогооням - Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн кино-радио механикч, жолооч, ахлагч

223. Лувсангийн Төмөрсүх - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн гүүрчин-аврагч, жолооч, ахлагч

224. Ганболдын Төмөрхүү - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн нярав-засварчин, дэд ахлагч

225. Эрдэнэбилэгийн Түвшинжаргал - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн штабын даргын харуул эрхэлсэн орлогч, дэслэгч

226. Цэндийн Түмэнбаяр - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн биеийн тамир, спортын дарга, ахлах дэслэгч

227. Эрдэнэсүрэнгийн Харцага - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний тасгийн дарга, дэслэгч

228. Гончигдоржийн Хатанбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ротын захирагч, ахлах дэслэгч

229. Чулуунбаатарын Цогтбаатар - Хилийн 0146 дугаар ангийн хилчин-шалгагч, ахлах ахлагч

230. Пүрэвийн Цэдэвсүрэн - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

231. Жадамбын Цэнгэлбаяр - Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн зэвсгийн дарга, хошууч

232. Агваандоржийн Цэрэнтогтох - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн ротын жагсаалын дарга, ахлагч

233. Баатархүүгийн Энхзоргол - ЗХЖШ-ын Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалын мэргэжилтэн, ахмад

234. Анхбаярын Энхсүх - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн зэвсгийн нярав- засварчин, дэд ахлагч

235. Гансүхийн Эрдэнэбат - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, дэд ахлагч

236. Базардэндэвийн Эрдэнэсайхан - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн шуудан хүргэгч, дэд ахлагч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 07-ны өдөр** | **Дугаар 235** | **Улаанбаатар хот**

**Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Паламын Сундэвийг тохоон томилсугай.

2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Баасанжавын Ганболдыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 21-ний өдөр** | **Дугаар 241** | **Улаанбаатар хот**

**Владимир Егорович Проничевыг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага, ОХУ-ын Хилийн албаны хооронд тогтсон найрамдалт харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, манай улсын хил хамгаалах байгууллагын боловсон хүчний мэргэшлийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны Хилийн албаны удирдагч, армийн генерал Владимир Егорович Проничевыг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 11-ний өдөр** | **Дугаар 248** | **Улаанбаатар хот**

**Цахилгаан шат шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 247 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "а" заалтын "30 хувийг улсын төсвөөс" гэснийг "55 хувийг улсын төсвөөс" гэж, "30 хувийг сууц өмчлөгчдийн холбооноос" гэснийг "5 хувийг сууц өмчлөгчдийн холбооноос" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд цахилгаан шат шинэчлэхэд зориулж тусгасан хөрөнгийг энэ онд багтаан бүрэн ашиглаж, ашиглалтын хугацаа дуусч, ашиглах боломжгүй болсон нь мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон орон сууцны байшингийн цахилгаан шатыг шинэчлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгаж, Сууц өмчлөгчдийн холбоодын Дээд зөвлөл (Б.ЖИГЖИД)-д зөвлөсүгэй.

3. "Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 247 дугаар тогтоолын дагуу сууц өмчлөгчдийн холбоо болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай хөрөнгийг хугацаанд нь гаргаж, орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж байхыг нийслэлийн Засаг дарга Т.Билэгтэд үүрэг болгож, Сууц өмчлөгчдийн холбоодын Дээд зөвлөл (Б.ЖИГЖИД)-д зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 18-ны өдөр** **Дугаар 252** **Улаанбаатар хот**

**Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.2, 16.1.1, 16.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Ухаа худагийн нүүрсний орд газраас Гашуун сухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Энержи Ресурс" ХХК-д олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Р.РАШ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 18-ны өдөр** **Дугаар 254** **Улаанбаатар хот**

**Зээл олгох тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 56.1, Тариалангийн тухай хуулийн 4.1.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж Өвөрхангай аймагт 1.0 (нэг) тэрбум, Говь-Алтай, Ховд, Завхан, Дархан-Уул аймагт тус бүр 500 (таван зуун) сая төгрөгийг төсвийн зээл хэлбэрээр олгохыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. "Атрын гурав дахь аян"-тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дээр дурдсан 5 аймагт нэмж олгосон зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 18-ны өдөр** **Дугаар 256** **Улаанбаатар хот**

**Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шатыг батлах тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 7.1.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын дунд хугацааны төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, батлагдсан төсвийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хуваарилан хүргүүлэхтэй холбогдсон дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үйл ажиллагааны үе шат, түүнийг хэрэгжүүлэх хуваарийг хавсралтын ёсоор батлагсугай.

2. Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шатыг төсвийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

3. Дунд хугацааны төсөв, төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагын хязгаар боловсруулахад шаардагдах төсвийн баримт бичиг, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд чанартай боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, бүх шатны төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төсвийн төлөвлөлтийн үе шатыг тогтоох тухай" Засгийн газрын 2004 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

Засгийн газрын 2008 оны 256 дугаар тогтоолын хавсралт

## ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

| № | Үйл ажиллагааны үе шат | Хугацаа |
|---|---|---|
| | Дунд хугацааны төсвийн хүрээ бэлтгэх | |
| 1 | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага макро эдийн засаг, төсвийн таамаглалын тооцоон дээр үндэслэн, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 25.2-т заасан макро эдийн засаг, төсвийн зорилтот үзүүлэлтүүд болон тооцоо танилцуулга, судалгаа гаргаж, Дунд хугацааны төсвийн хүрээний төсөл (цаашид "ДХТХ" гэх)-ийг боловсруулна | Ш/15-ны дотор |
| 2 | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ДХТХ-ны төслийг Засгийн газарт хүргүүлнэ | Ш/15-ны дотор |
| 3 | Засгийн газар ДХТХ-ны төслийг хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ | IY/5-ны дотор |
| | Дунд хугацааны төсвийн зарлагын хязгаар бэлтгэх | |
| 4 | Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн эцсийн санхүүгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлангийн нэгтгэл, дунд хугацаанд баримтлах салбарын бодлогын чиглэл, зорилт, хүрэх үр дүнг агуулсан Бодлогын мэдэгдэл, шинээр эхлүүлэх хөтөлбөр өртгийн тооцоог багтаасан төсвийн хувилбарт тооцоог тус тус тодорхойлж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ | Y/10-ны дотор |
| 5 | Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн салбарын дунд хугацааны бодлогын тодотгосон чиглэл, төсвийн хувилбарт тооцоо, жилийн эцсийн санхүүгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг үндэслэн Улсын Их Хурлаас зөвшөөрсөн ДХТХ-ны дунд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн зарлагын хязгаарыг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ | Y/20-ны дотор |
| 6 | Засгийн газар Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн зарлагын хязгаарыг хэлэлцэн батална | YI/1-ний дотор |
| 7 | Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн зарлагын хязгаарыг олон нийтэд хэвлэн нийтэлнэ | YI/15-ны дотор |
| | Дунд хугацааны төсөв бэлтгэх | |
| 8 | Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн зарлагын хязгаарыг, төсөв боловсруулах удирдамжийн хамт төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ | YI/10-ны дотор |
| 9 | Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарлагын хязгаарыг аймаг, нийслэл болон төрийн захиргааны байгуулага (агентлаг) бүрээр боловсруулан хүргүүлнэ | YI/15-ны дотор |
| 10 | Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүрэг бүрээр төсвийн зарлагын хязгаарыг боловсруулан хүргүүлнэ | YI/25-ны дотор |

| | | |
|---|---|---|
| 11 | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх тухайн салбарын асуудал хариуцсан ажлын алба төсвийн зарлагын хязгаарт багтаан Дунд хугацааны төсвийн төслийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний хамт аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ | VII/5-ны дотор |
| 12 | Аймаг, нийслэлийн Засаг дарга болон түүний харьяа төрийн захиргааны байгууллага (агентлаг) төсвийн зарлагын хязгаарт багтаан Дунд хугацааны төсвийн төслийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний хамт төсвийн ерөнхийлөн захирагч нарт ирүүлнэ | VII/15-ны дотор |
| 13 | Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төслийг төсвийн зарлагын хязгаарт багтаан боловсруулж, Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ | VIII/15-ны дотор |
| 14 | Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн дунд хугацааны төсвийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч бүртэй хэлэлцэн тохиролцож, Монгол Улсын дунд хугацааны төсвийн төслийг боловсруулна | IX/15-ны дотор |
| 15 | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын дунд хугацааны төсвийн төслийг Засгийн газарт хүргүүлнэ | IX/15-ны дотор |
| 16 | Монгол Улсын дунд хугацааны төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дунд хугацааны төсвийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ | X/1-ний дотор |
| 17 | Улсын Их Хурлаас Монгол Улсын төсвийг батална | XII/1-ний дотор |
| | Төсвийн хуваарь батлах, хүргүүлэх | |
| 18 | Улсын Их Хурлаар батлагдсан Дунд хугацааны төсвийг (Төсвийн тухай хууль болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсөв) олон нийтэд мэдээлнэ | XII/8-ны дотор |
| 19 | Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Улсын Их Хурлаас баталсан жилийн төсвийг дэлгэрэнгүй үзүүлэлтээр төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ | XII/10-ны дотор |
| 20 | Төсвийн ерөнхийлөн захирагч бүр аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон төсвийн ерөнхий менежерүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үр дүнгийн гэрээ байгуулна | XII/25-ны дотор |
| 21 | Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн төсвийн багцын сар, улирлын санхүүжилтийн хуваарийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ | I/5-ны дотор |
| 22 | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан аймаг, нийслэлийн төсвийг дэлгэрэнгүй үзүүлэлтээр санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ | I/5-ны дотор |
| 23 | Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага ирэх жилийн төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг баталж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ | I/10-ны дотор |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

"Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 51 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох журам"-ыг хавсралтын ёсоор батлсугай.

2. Малчдаас зах зээлд борлуулаагүй монгол ямааны ноолуурын үлдэгдлийн талаарх мэдээг сум бүрээр гаргаж 2008 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Малчдаас ноолуур худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, ноолуурын зах зээлийн үнийг тогтворжуулахад хяналт тавих комиссыг нутгийн захиргааны үйлдвэрлэгч байгууллага, ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний үйлдвэрлэгч, малчдын төлөөлөлтэйгээр аймаг бүрт байгуулан ажиллуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Монгол ямааны ноолуурын чанар, зэрэглэлийг харгалзан нэг килограммыг нь 30000-32000 мянган төгрөгөөр малчдаас худалдан авах үйл ажиллагааг шалгарсан үндэсний аж ахуйн нэгжүүдтэй хамтран нэн даруй эхлүүлж 2008 оны 8 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Сонгон шалгарсан үндэсний аж ахуйн нэгжийг эргэлтийн хөрөнгөөр таатамжтай нөхцөлөөр хангахад чиглэсэн гурван талт санамж бичгийг Монголын банкуудын холбоо, Монголын ноос, ноолуурын холбоотой зөвшилцөн байгуулж ажиллах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү нарт даалгасугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, явцыг Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Х.НАРАНХҮҮ**

Засгийн газрын 2008 оны 260 дугаар тогтоолын хавсралт

### МАЛЧДААС МОНГОЛ ЯМААНЫ НООЛУУР ХУДАЛДАН АВСАН ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТАТААС ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. "Мах, ноолуурын үнийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолыг үндэслэн "Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан"-гаас малчдаас монгол ямааны ноолуурыг чанар, зэрэглэлийг харгалзан 1 килограммыг нь 30000–32000 төгрөгөөр худалдан авсан ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг үндэсний аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгохтой холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Энэхүү журам нь Монгол Улсын татварын албанд болон нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид хамаарна.

3. Ноолуурын үнийн хэлбэлзлийг хянах, ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох эсэхийг зохих журмын дагуу шалгаруулан Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зөвлөлд хүсэлт гаргах эрх бүхий комисс гүйцэтгэнэ. Комиссын бүрэлдэхүүнийг Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар байгуулна.

*Хоёр. Аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах*

4. Журамд хамрагдах аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох асуудлаар комисс тодорхойлолт гаргана.

5. Комисс нь тодорхойлолт гаргахдаа дараахь шалгуур үзүүлэлтийг үндэслэнэ:

5.1. тухайн аж ахуйн нэгж ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг 3-аас доошгүй жил тогтвортой эрхэлсэн байх;

5.2. чанар, зэрэглэлийг харгалзан 17,5 микроноос дээшгүй нарийнтай 1 кг монгол ямааны ноолуурыг 30000-32000 төгрөгөөр малчдаас болон малчдын бүлгийн төлөөллөөс тухайн аймгийн төвөөс худалдан авах баталгаа гаргасан байх.

6. Шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж дараахь бичиг баримтыг бүрдүүлэн зээлийн хүүгийн татаас авах хүсэлтээ гаргаж, комисст хүргүүлнэ:

6.1. аж ахуйн нэгжийн болон нийгмийн даатгалын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

6.2. мэргэжлийн холбооны санал, дүгнэлт;

6.3. хамтран ажиллах тухай арилжааны банкны албан бичиг;

6.4. тухайн арилжааны банкны зээлийн хорооны шийдвэр, зээлийн хэмжээ, зээл олгох болон зээлийн үндсэн төлбөр, хүү эргэн төлөх хуваарь.

Гурав. Комиссын эрх, үүрэг

7. Комисс нь асуудлыг хуралдаанаараа хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8. Комисс нь дараахь эрхтэй байна:

8.1. энэхүү журмын 5-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзах;

8.2. эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаасын хөрөнгийг байршуулсан банкнаас татах санал гаргах, энэ талаархи дүгнэлтээ Хөрөнгө оруулалт, хөгжлийн санд ирүүлэх;

8.3. зохих журмын дагуу журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах;

8.4. ноолуур худалдан авсан тайлан болон холбогдох материалыг шаардан авах, үйл ажиллагааны чиглэл өгөх.

9. Комисс нь дараахь үүрэгтэй байна:

9.1. зээлийн хүүгийн татаас авахаар хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн хүсэлтийг судалж, тодорхойлолт гаргах;

9.2. арилжааны банкнаас тухайн аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн зээл олгохыг зөвшөөрсөн тохиолдолд Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зөвлөлд зохих журмын дагуу уламжлах;

9.3. эргэлтийн хөрөнгийн зээл авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах.

Дөрөв. Зээлийн хүүгийн татаасыг байршуулах, санхүүжүүлэх

10. Шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаасыг арилжааны банкинд байршуулах, санхүүжүүлэх харилцааг төсөв, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмын дагуу зохицуулна.

11. Журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь гадаадын банкинд хамаарахгүй.

Тав. Зээлийн хүүгийн татаас олгох

12. Ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг нэг аж ахуйн нэгжид олгох эргэлтийн хөрөнгийн зээлийн хугацаа нь 1 жил 6 сар хүртэл байна.

13. Арилжааны банк ноолуур бэлтгэх үйлдвэрлэгчдэд зээл олгосон нөхцөлд зээлийн хүүгийн 50 хувийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.

Зургаа. Хяналт, тайлагналт

14. Комисс нь энэхүү журамд хамрагдсан аж ахуйн нэгжийн байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг гаргаж, Сангийн яаманд хүргүүлнэ.

15. Ноолуур худалдан авах аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдсан комисс зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж хяналт тавина. Энэхүү комисс нь тухайн аймгаас худалдан авсан ноолуурын мэдээг аж ахуйн нэгж бүрээр гарган Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ.

16. Үйлдвэр, худалдааны яам нь Монголын ноос, ноолуурын холбооноос хүлээн авсан тайланд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Сангийн яаманд хүргүүлнэ.

17. Гэрээний нөхцөлийг зөрчсөн, хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд гэрээг цуцлах саналыг Үйлдвэр, худалдааны яам Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлнэ.

Долоо. Хариуцлага

18. Аж ахуйн нэгж хуурамч материал бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд асуудлыг зохих журмын дагуу хуулийн байгууллагад шилжүүлнэ.

19. Аж ахуйн нэгж, холбогдох ажилтнууд энэхүү журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нэн даруй зөрчлийг арилгаж, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 261** **Улаанбаатар хот**

**Хүүхдийн төлөө сангийн дүрэм, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.3, 18, 26.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Хүүхдийн төлөө сангийн дүрмийг 1 дүгээр хавсралт, сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Ч.Улаан, сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хүүхдийн төлөө сангийн дүрэм батлах тухай" Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХБОЛД**

**Засгийн газрын 2008 оны 261 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт**

### ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Хүүхдийн төлөө сан (цаашид "сан" гэх)-ийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбоотой харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2 Сангийн зорилго нь хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн зохих эх үүсвэрийг үндэсний хэмжээнд бүрдүүлэх, хүүхдийн төлөө зориулж байгаа хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулахад оршино.

1.3. Сангийн үйл ажиллагаа нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.4. Сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулна.

1.5 Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

1.6. Сан нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

2.1. Сангийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

2.1.1. улсын төсвийн хөрөнгө;

2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

2.1.3. гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл.

2.2. Сангийн хөрөнгийг хүүхдийн хөгжил, хамгааллын цогц бодлого, чиглэлд нийцсэн дараахь арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

2.2.1. Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлого, чиглэлд нийцсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

а) хүүхдийг дарамт, хүчирхийллээс хамгаалах чиглэлээр гэр бүлийг чадваржуулах сургалт, сурталчилгаа;

б) хүүхдийн амралт, чөлөөт цаг, хөгжлийг дэмжих орчин бүрдүүлэх болон хүүхдийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх зорилготой үйл ажиллагаа;

в) хүүхэд хамгааллын нэн шаардлагатай үйлчилгээг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд өргөжүүлэх;

2.2.2. Хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах онцгой нөхцөлд тусламж үзүүлэх:

а) хүүхдийн эрхийг хангах байдлыг хянах мэдээлэл-мониторингийн тогтолцоог бэхжүүлэх;

б) гамшиг, ослын үед хүүхдэд яаралтай тусламж, тэдгээрт зориулан нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах;

2.2.3. Хүүхэд, өсвөр үеийнхний гишүүнчлэл бүхий төрийн бус байгууллагын зарим үйл ажиллагааг дэмжин хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг сонсох үндэсний болон бүсийн хэмжээний арга хэмжээ зохион байгуулах.

2.3. Тухайн санхүүгийн жилд зарцуулаагүй сангийн хөрөнгийн үлдэгдлийг дараа жилийн төсөвт нэмж тусган батлуулна.

Гурав. Сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих

3.1. Сангийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гаргана.

3.2. Төрийн аудитын байгууллага сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

3.3. Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлтийн хамт тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Сангийн удирдлага, зохион байгуулалт, ажиллах журам

4.1. Сангийн удирдах зөвлөл нь орон тооны бус 13 гишүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Зөвлөлийг хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

4.2. Сангийн гүйцэтгэх захирал нь Хүүхдийн төлөө Үндэсний газрын дарга байна.

4.3. Сан нь хандивлагч гишүүнтэй байж болно.

4.4. Сангийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно.

4.5. Удирдах зөвлөл асуудлыг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Сангийн удирдах зөвлөлийн тогтоолд сангийн тэргүүн, гүйцэтгэх захирал гарын үсэг зурна.

4.6. Удирдах зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, сангийн гүйцэтгэх захирал гарын үсэг зурна.

4.7. Сангийн удирдах зөвлөл нь дараахь үүрэг хүлээнэ:

4.7.1. сангийн хөрөнгийн төлөвлөлтийн талаар хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тодорхой санал тавих;

4.7.2 сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

4.7.3. сангийн хөрөнгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг идэвхжүүлэх;

4.7.4. сангийн үйл ажиллагаа болон сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах;

4.7.5. сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

4.8. Сангийн удирдах зөвлөл дараахь эрх эдэлнэ:

4.8.1. сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах;

4.8.2. сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаархи тайланг хэлэлцэн дүгнэлт өгөх;

4.8.3. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг даалгавар өгөх;

4.8.4. сангийн үйл ажиллагааны тайлан, үр дүн, холбогдох мэдээ, мэдээлэл, судалгааг мэргэжлийн байгууллагаас гаргуулан авах;

4.8.5. олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

4.8.6. санд хөрөнгө хандивлаж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулан дэмжих.

Засгийн газрын 2008 оны 261 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**Сангийн тэргүүн** - Монгол Улсын Шадар сайд

**Гүйцэтгэх захирал** - Хүүхдийн төлөө Үндэсний газрын дарга

**Гишүүд:** - Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн бодлого төлөвлөлтийн газрын дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын газрын дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлого зохицуулалтын газрын дарга;

-Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын дарга;

-Байгаль орчны яамны Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газрын дарга;

-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал;

-Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);

-"Номин холдинг" ХХК-ийн ерөнхий захирал;

-"Голомт" банкны ерөнхий захирал.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 263** **Улаанбаатар хот**

**Цөмийн энергийн талаар авах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн 5.1, Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд Цөмийн энергийн комисс-Засгийн газрын тохируулагч агентлагийг байгуулсугай.

2. Улсын хэмжээнд цөмийн судалгаа, технологийг хөгжүүлэх, цацрагийн үүсгүүрийг ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах асуудлыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Цөмийн энергийн үндэсний комиссын бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор батлсугай.

3. Цөмийн энергийн комисс-Засгийн газрын тохируулагч агентлаг байгуулагдсантай холбогдуулан мэргэжлийн хяналтын байгууллагын бүтцэд цацрагийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ажилтнуудыг орон тоо, цалингийн сан, холбогдох зардал, тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгийн хамт тус комисст шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд, нийслэлийн Засаг дарга Т.Билэгт нарт даалгасугай.

4. Цөмийн энергийн комисс-Засгийн газрын тохируулагч агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөл, зохион байгуулалтын бүтэц, орон тооны болон төсвийн зардлын хязгаарын төслийг боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Н.БОЛОРМАА**

Засгийн газрын 2008 оны 263 дугаар тогтоолын хавсралт

## ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

**Комиссын дарга** - Монгол Улсын Ерөнхий сайд

**Орлогч дарга** - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

**Гишүүд:** - Сангийн сайд;

-Гадаад хэргийн сайд;

-Хууль зүй, дотоод хэргийн сайд;

-Байгаль орчны сайд;

-Барилга, хот байгуулалтын сайд;

-Батлан хамгаалахын сайд;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд;

-Түлш, эрчим хүчний сайд;

-Үйлдвэр, худалдааны сайд;

-Хүнс, хөдөө аж ахуйн сайд;

-Эрүүл мэндийн сайд;

-Тагнуулын ерөнхий газрын дарга;

-Онцгой байдлын ерөнхий газрын дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;

-Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч (тохиролцсоноор).

**Нарийн бичгийн дарга:** -Цөмийн энергийн комисс-Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 264** | **Улаанбаатар хот**

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотноо 2004 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан "Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг батлагсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Б.БАТСЭРЭЭДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 06 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 266** | **Улаанбаатар хот**

### Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай

Дипломат албаны тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Гадаадад ажиллах томилолтын хугацаа нь дууссантай холбогдуулан Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Кызыл хотод суугаа Ерөнхий консул Чойжинжавын Сумаахүүг эгүүлэн татсугай.

2. Дашбалбарын Базарсадыг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Кызыл хотод суух Ерөнхий консулаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД С.ОЮУН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 07 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 282 | Улаанбаатар хот

**Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.5, Онцгой албан татварын тухай хуулийн 6.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11.4, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 43 дугаар тогтоол, "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлж бензин шатахууны нөөц хэлбэрээр байршуулах газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх, хадгалах, худалдах, нөхөн бүрдүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр улсын хэмжээнд бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан журмын дагуу 2008 оны 7, 8 дугаар сард багтаан газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн хадгалах тухай гурвалсан гэрээ байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгаж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд үүрэг болгосугай.

3. 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс мөн оны 7 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд улсын хилээр импортолж байгаа болон дотоодын зах зээлд худалдан борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг "О" хувь, нэмэгдсэн өртгийн албан татварыг 5 хувиар; 2008 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс онцгой албан татварыг "О" хувь, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг "О" хувиар тус тус тогтоосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 247 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтийн талаар Засгийн газарт тогтмол танилцуулж байхыг Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**САНГИЙН САЙД Ч.УЛААН**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Х.НАРАНХҮҮ**

**Засгийн газрын 2008 оны 282 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

### МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЖ БЕНЗИН ШАТАХУУНЫ НӨӨЦ ХЭЛБЭРЭЭР БАЙРШУУЛАХ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХУДАЛДАН АВАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДАХ, НӨХӨН БҮРДҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.5-д заасныг болон "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2008 оны 48 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлж бензин шатахууны нөөц хэлбэрээр байршуулах газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх, хадгалах, худалдах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Энэхүү журмыг газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх,

хадгалах, худалдах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж дагаж мөрдөнө.

3. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдан авах, худалдах асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

4. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, байршлыг газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид "гэрээт хадгалагч" гэнэ) тус бүрээр Засгийн газар тогтооно.

Хоёр. Нэр томъёо

5. Энэхүү журамд дурдсан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1. "Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн" гэж Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлж бензин шатахууны нөөц хэлбэрээр байршуулж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг;

5.2. "Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн" гэж автобензин (А-80, АИ-92 тэдгээртэй адилтгах шинж чанар бүхий автобензин), дизелийн түлшийг;

5.3. "Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдол" гэж тухайн сарын захиалгат газрын тосны бүтээгдэхүүний тоо хэмжээний 50-иас доош хувийг нийлүүлснээс үүссэн нөхцөл байдлыг;

5.4. "Төрийн чухал үйлчилгээ" гэж эмнэлгийн түргэн тусламж, цагдаа, онцгой байдал, хил хамгаалах алба, төрийн болон орон нутгийн өмчийн том оврын нийтийн тээврийн үйлчилгээг.

Гурав. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн худалдан авах, тээвэрлэх

6. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон нэр төрөл, тоо хэмжээгээр газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх талаар экспортлогч болон тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, импортлох, тээвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулна.

Дөрөв. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн байршуулах, хадгалах

7. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, хадгалах нөхцөлийг төсвийн болон газрын тосны бүтээгдэхүүний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, гэрээт хадгалагч хооронд байгуулсан газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах гурвалсан гэрээгээр зохицуулна.

8. Энэхүү журмын 7-д заасан газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн хадгалах гэрээнд нөөцийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, стандарт, байршил, хадгалах хугацаа, хадгалалтын төлбөрийн дээд хэмжээ, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, хяналт, мэдээ тайлан гаргах болон бусад нөхцөлийн талаар тодорхой тусгана.

9. Гэрээт хадгалагчийн газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн хадгалах төлбөрийн дээд хэмжээг төсвийн болон газрын тосны бүтээгдэхүүний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Тав. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдах

10. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд төсвийн орлогын дутагдлыг нөхөх болон газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг найдвартай байлгах, үнийн өсөлтийг сааруулах зорилгоор төсвийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнээс худалдах нэр төрөл, тоо хэмжээ, байршил, газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид худалдах бөөний үнэ болон жижиглэн худалдааны үнийн дээд хязгаарыг Засгийн газар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.

11. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төсөлд дараах асуудлыг тусгана:

11.1. газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хомсдол үүссэн нөхцөлд газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнээс төрийн чухал үйлчилгээний хэрэгцээнд зориулан худалдах нэр төрөл, тоо хэмжээ, үнийн хязгаар;

11.2. газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтийг саармагжуулах зорилгоор газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнээс худалдах нэр төрөл, тоо хэмжээ, үнийн хязгаар;

11.3. газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг нөхөн бүрдүүлэх асуудал.

12. Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэн газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааг Засгийн газрын шийдвэрийн дагуу зохион байгуулна.

13. Гэрээт хадгалагч нь өөрийн эзэмшлийн агуулахад хадгалагдаж байгаа газрын тосны

нөөцийн бүтээгдэхүүнээс эхний ээлжинд худалдан авах давуу эрх эдэлнэ.

14. Худалдан авагч нь бүтээгдэхүүний төлбөрийг хуанлийн 14 хоногийн дотор Төрийн сан дахь Монгол Улсыг хөгжүүлэх сангийн дансанд шилжүүлнэ. Худалдан авагч нь төлбөр төлөх хугацаа хэтэрсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлнө.

Зургаа. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үүрэг

15. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг байршуулах гэрээт хадгалагчид уг бүтээгдэхүүнийг нэр төрөл, тоо хэмжээ, чанарыг заасан баримт бичиг үйлдэж хүлээлгэн өгнө.

16. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын тогтоолын дагуу "Худалдах, худалдан авах гэрээ" байгуулж газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдаж, төлбөрийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.

Долоо. Гэрээт хадгалагчийн үүрэг

17. Гэрээт хадгалагч нь газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу хадгалах бөгөөд энэхүү шаардлагыг зөрчсөний улмаас үүдэх хохирол, эрсдэлийг бүрэн хариуцна.

18. Гэрээт хадгалагч нь гэрээнд заасан үүргээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх, эрх бүхий холбогдох байгууллагын шийдвэр гараагүй байхад газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, байршлыг өөрчлөх, нөөцийг өөр зорилгоор ашиглах, зарцуулахгүй байх үүрэг хүлээнэ.

19. Гэрээт хадгалагч нь энэ журамд заасан үүргийг зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 424.1-д заасны дагуу учирсан хохирлыг нөхөн төлнө.

Найм. Мэдээ, тайлан

20. Газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний мэдээ, борлуулалтын болон үлдэгдлийн мэдээг гаргах маягт, зааврыг төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

21. Гэрээт хадгалагч нь газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний борлуулалтын болон үлдэгдлийн мэдээ, тайланг гэрээнд заасан хугацаанд үнэн зөв гаргаж газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

22. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гэрээт хадгалагчаас ирүүлсэн газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний борлуулалтын болон үлдэгдлийн мэдээ, тайланг хянаж нэгтгэн ажлын 3 хоногт багтаан төсвийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

23. Төсвийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний борлуулалтын болон үлдэгдлийн мэдээ, тайланг Засгийн газарт танилцуулна.

Ес. Хяналт тавих

24. Төсвийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх, хадгалах, худалдах үйл ажиллагаанд хяналт тавина.

25. Гэрээт хадгалагчтай байгуулсан гэрээний биелэлтэд төсвийн болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын болон газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

26. Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь "Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал MNS 4633:2006" стандартын дагуу газрын тосны нөөцийн бүтээгдэхүүнд сар бүр чанарын шинжилгээ, хэмжилт хийж, акт үйлдэн баталгаажуулна.

Засгийн газрын 2008 оны 282 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН 2008 ОНД МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРДҮҮЛЭХ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨӨЦИЙН НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

| № | Нөөц байршуулах гэрээт хадгалагч | д/д | Аймаг, нийслэлийн нэр | Байршил | Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээ /тонноор/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | А-80 | Дизелийн түлш | АИ-92 | Нийт |
| 1 | "НИК" ХК | 1 | Улаанбаатар | Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо | 4380 | 6000 | 1824 | 12204 |
| | | 2 | Улаанбаатар | Багануур дүүрэг | 250 | 300 | 280 | 830 |
| | | 3 | Дархан-Уул | Дархан сум, 3 дугаар баг | 1400 | 2700 | 431 | 4531 |
| | | 4 | Дархан-Уул | Шарын гол | 70 | 800 | - | 870 |
| | | 5 | Орхон | Улаантолгой | 4260 | 4301 | 428 | 8989 |
| | | 6 | Орхон | Эрдэнэт | - | 269 | 431 | 700 |
| | | 7 | Сэлэнгэ | Сүхбаатар сум | 90 | 138 | 101 | 329 |
| | | 8 | Сэлэнгэ | Зүүнхараа хот | 170 | 419 | - | 589 |
| | | 9 | Сэлэнгэ | Сайхан сум, Хөтөл агуулах | 150 | 202 | - | 352 |
| | | 10 | Увс | Улаангом сум | 400 | 400 | - | 800 |
| | | 11 | Дорнод | Хэрлэн сум, 3 дугаар баг | 1800 | 1000 | 120 | 2920 |
| | | 12 | Дорнод | Төмөр замын агуулах | - | 672 | - | 672 |
| | | 13 | Дорноговь | Сайншанд сум, 3 дугаар баг | 360 | 1400 | - | 1760 |
| | | 14 | Баян-Өлгий | Өлгий хот | 300 | - | - | 300 |
| | | 15 | Ховд | Ховд хот | 1140 | 403 | - | 1543 |
| | | 16 | Говьсүмбэр | Сүмбэр сум, I дүгээр баг | 3000 | 2200 | 890 | 6090 |
| | | 17 | Хэнтий | Өндөрхаан сум | 653 | 1100 | - | 1753 |
| | | 18 | Завхан | Улиастай сум | 944 | 991 | - | 1935 |
| | | | | Дүн | 19367 | 23295 | 4505 | 47167 |
| 2 | "Петровис" ХХК | 1 | Улаанбаатар | Сонсголон | - | 800 | - | 800 |
| | | 2 | Дархан-Уул | Дархан | 90 | 101 | 61 | 252 |
| | | | | Дүн | 90 | 901 | 61 | 1052 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | "Магнай трейд" ХХК | 1 | Улаанбаатар | Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо | 5950 | 5520 | 5085 | 16555 |
| | | 2 | Дархан-Уул | Дархан сум, 15 дугаар баг | 1500 | 1540 | 940 | 3980 |
| | | 3 | Орхон | Баян-Өндөр сум | 480 | 200 | 120 | 800 |
| | | 4 | Сэлэнгэ | Сүхбаатар сум, 4 дүгээр баг | 150 | 190 | 100 | 440 |
| | | 5 | Сэлэнгэ | Зүүнхараа хот | 360 | 60 | - | 420 |
| | | 6 | Говь-Алтай | Есөнбулаг сум | 900 | 300 | - | 1200 |
| | | 7 | Говь-Алтай | Алтай сум | 240 | - | 120 | 360 |
| | | 8 | Увс аймаг | Улаангом сум | 480 | 120 | - | 600 |
| | | 9 | Дорнод | Хэрлэн сум, 8 дугаар баг | 1200 | 1200 | 700 | 3100 |
| | | 10 | Дорноговь | Сайншанд сум, 3 дугаар баг | 180 | 180 | 60 | 420 |
| | | 11 | Ховд | Булган сум | 480 | - | - | 480 |
| | | 12 | Хөвсгөл | Мөрөн хот | 100 | 30 | 15 | 145 |
| | | | | Дүн | 12020 | 9340 | 7140 | 28500 |
| 4 | "Шунхлай групп" ХХК | 1 | Улаанбаатар | Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо | 700 | 3080 | 2067 | 5847 |
| | | 2 | Дархан-Уул | Дархан сум, 3 дугаар баг | 53 | 693 | 20 | 766 |
| | | 3 | Орхон | Баян-Өндөр сум | 52 | 693 | 52 | 797 |
| | | 4 | Сэлэнгэ | Сүхбаатар сум, 4 дүгээр баг | 66 | 110 | 13 | 189 |
| | | 5 | Дорноговь | Сайншанд сум, 4 дүгээр баг | 17 | 68 | 397 | 482 |
| | | | | Дүн | 888 | 4644 | 2549 | 8081 |
| 5 | "Жаст Ойл" ХХК | 1 | Улаанбаатар | Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо | 1025 | 4120 | 2945 | 8090 |
| | | 2 | Орхон | Баян-Өндөр сум | 120 | 110 | 55 | 285 |
| | | 3 | Сэлэнгэ | Сүхбаатар сум | 55 | 110 | - | 165 |
| | | | | Дүн | 1200 | 4340 | 3000 | 8540 |